



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2004 оны 8 сарын 12 өдөр

Дугаар 370

Улаанбаатар хот

**Бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн
тогтоох тухай**

Монгол Улсын Засгийн газрын 2004 оны 182 дугаар тогтоолыг үндэслэн
ЗАХИРАМЖЛАХ НЬ:

Нэг. Бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн тогтоож байгаатай холбогдуулан Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг "Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газар", Улаанбаатар хотын захирагчийн харъяа "Зам тээврийн газар", Засаг даргын Тамгын газрын "Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс"-ийг 2004 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөр тасалбар болгон тус тус татан буулгасугай.

Хоёр. Дээрх газруудыг татан буулгасантай холбогдуулан 2004 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөр тасалбар болгон М.Цэлмэгийг Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газрын, Т.Пүрэвдоржийг Зам тээврийн газрын, Ч.Батыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүрэгт ажлаас тус тус чөлөөлсүгэй.

Гурав. Бүтэц, зохион байгуулалтын шинэчлэлтэй холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт Хот байгуулалт, хотын хөгжлийн стратеги, урт, дунд, богино хугацааны хөтөлбөр, төсөл, төлөвлөлтийн асуудал хариуцсан "Хот байгуулалт, стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс", Улаанбаатар хотын Захирагчийн харъяанд хотын нийтийн тээврийн үйлчилгээний нэгдсэн удирдлага зохицуулалтын асуудал хариуцсан "Нийтийн тээвэр, зохицуулалтын газар", хотын хөрөнгө оруулалтаар хийгдэх ажил болон зам засвар, арчлалт, хамгаалалтын хөрөнгийг төвлөрүүлж, зарцуулах үүрэг бүхий Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг "Хөрөнгө оруулалтын газар"-ыг тус тус байгуулсугай.

Дөрөв. 2004 оны 08 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн Ч.Батыг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хот байгуулалт, стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн, М.Цэлмэгийг Хөрөнгө оруулалтын газрын, Т.Пүрэвдоржийг Нийтийн тээвэр зохицуулалтын газрын даргаар тус тус томилон ажиллуулсугай.

Тав. Нийслэлийн "Хөрөнгө оруулалтын газар"-ыг Захиргаа, аж ахуй, Хөрөнгө оруулалт, Зам, замын байгууламжийн гэсэн 3 хэлтэс, замын материалын лабораторитойгоор орон тооны дээд хязгаарыг 42, "Нийтийн тээвэр, зохицуулалтын газар"-ыг Тамгын, Эдийн засаг, санхүүгийн, Тээврийн, Хөдөлгөөний бүртгэл мэдээллийн, Хяналт шалгалтын гэсэн 5 хэлтэстэйгээр орон тооны дээд хязгаарыг 105 хүртэл байхаар тус тус баталсугай.

Зургаа. Дээрхи хэлтэс, газруудыг байгуулсантай холбогдуулан "Зам тээврийн газар"-ын Замын хэлтэс, /Замын материалын лабораторийн хамт/-ийг орон тоо, үндсэн хөрөнгөтэй нь "Хөрөнгө оруулалтын газар"-т, Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газрын бүтцэд байсан "Хот байгуулалт, мэдээлэл технологийн төв"-ийг орон тоо, үндсэн хөрөнгөтэй нь Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ зураг, төслийн хүрээлэнд, Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газрын хот байгуулалтын чиг үүргийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хот байгуулалт, стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст, Хот байгуулалт, хөрөнгө оруулалтын газрын улсын УБХ- 65-09 дугаар бүхий Пажеро маркийн автомашиныг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Авто баазад тус тус шилжүүлсүгэй.

Долоо.Бүтэц зохион байгуулалтыг шинэчлэн тогтоож байгаатай холбогдуулан "Хот байгуулалт, стратегийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс", "Хөрөнгө оруулалтын газар", "Нийтийн тээвэр зохицуулалтын газар", "Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэн"-ийн дүрмийг шинэчлэн боловсруулан батлуулах, төсвийн ерөнхийлөн захирагч, ерөнхий менежертэй байгуулсан үр дүнгийн гэрээг шинэчлэн хийхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын "Хот байгуулалт, стратегийн бодлого төлөвлөлтийн хэлтэс /Ч.Бат/, "Хөрөнгө оруулалтын газар" /М.Цэлмэг/, "Нийтийн тээвэр зохицуулалтын газар" /Т.Пүрэвдорж/, Хот төлөвлөлт, эрдэм шинжилгээ, зураг төслийн хүрээлэн /Д.Мижидсүрэн/ нарт даалгасугай.

Найм. Энэ захирамж гарсантай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын 2003 оны 48 дугаар, 2002 оны 87 дугаар захирамжийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
 БӨГӨӨД УЛААНБААТАР
 ХОТЫН ЗАХИРАГЧ

(Handwritten signature)

М.ЭНХБОЛД